

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /6-р сарын 12-ноос 7-р сарын 10-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	VI/12	VI/19	VI/25	VII/03	VII/10
1	Гурил, I зэрэг, кг	650	650	650	650	650
2	Хонины мах, кг/ ястай/	7800	7500	7500	7500	7500
3	Үхрийн мах, кг /ястай/	зарагдаагүй	9500	9500	9500	9500
4	Ямааны мах /ястай /	6500	6000	6000	6500	6500
5	Элсэн чихэр, кг	1480	1480	1480	1480	1480
6	Цагаан будаа, кг	1600	1600	1600	1600	1600
7	Шингэн сүү, л	800	800	700	700	700
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	60000	60000	зарагдаагүй	зарагдаагүй	55000
9	- Бор ноолуур	60000	60000	зарагдаагүй	зарагдаагүй	55000
10	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1550
11	Бензин, А-92, 1 литр	1650	1650	1650	1650	1650
12	Дизелийн түлш, 1 литр	1750	1750	1750	1750	1750

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2013 оны 6-р сарын 12-ноос 7-р сарын 10-ны хооронд үхрийн мах, гурил, элсэн чихэр, цагаан будаа, бензин шатахууны үнэ тогтвортой байж бусад бараа бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөв.

Махны үнэ. Үхрийн ястай мах 6-р сарын 12-нд зарагдаагүй бол 6-р сарын 19-нөөс 7-р сарын 10-ны хооронд 1кг нь 9500 төгрөгийн ханштай байв. Хонины ястай мах 1 кг нь 6-р сарын 12-нд 7800 төгрөгийн ханштай байсан бол 6-р сарын 19-нөөс 7-р сарын 10-н хүртэл 3,8%-аар буурч 7500 төгрөг байв. Ямааны ястай мах мөн 6-р сарын 19-нд өмнөх 7 хоногийн ханштай харьцуулахад 7,7%-аар буурч 6000 төгрөг болоод 7-р сарын 3-наас 6500 төгрөг болж ханш өсөв.

Шингэн сүүний үнэ тогтмол буурсаар байгаа ба 6-р сарын 25-нд 700 төгрөг болж өмнөх 7 хоногоос 100 төгрөгөөр буурав.

Ямааны ноолуур бор, цагаан өнгө ялгалгүй ижил үнэтэй байгаа ба 6-р сарын 12, 19-ний өдөр 60000 төгрөгт хүрсэн бол 6-р сарын 25, 7-р сарын 3-нд ноолуурын арилжаа хийгдэлгүй 7-р сарын 10-нд 55000 төгрөгийн ханштай байв.



